

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/190/НА-СТА-ТӨА

БАРУУН ЗУУНМОД ББН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272287 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4.1 Ерөнхий зүйл	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.2 Албан шаардлага	13
5.3 Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 01/206
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт орж үзүүлсэн тусламж, үйлчилгээний тохиолдлоор буюу гүйцэтгэлээр нь санхүүжүүлдэг болсны үр дүнд иргэнээ дагасан санхүүжилтийн тогтолцоо бий болж, санхүүгийн эрсдэл, чирэгдэл буурах, эмнэлгийн санхүүгийн менежмент сайжрах, эмч, эмнэлгийн ажилчдын цалин нэмэгдэх боломжтой болсон байна

Аудитын гол асуудал

Төв аймгийн Баруун Зуунмод ББН өрхийн эрүүл мэндийн төв нь 2023 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, хорт хавдар, гэмтэл, түлэгдэлт, тархины цус харвалтын зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн үзүүлсний үр дүнд 754,840.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч үйл ажиллагаандаа бүрэн зарцуулсан байна

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****(Төгрөгөөр)**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	112,174,169.90	136,646,353.5
35	БАРАА МАТЕРИАЛ	112,174,169.90	136,646,353.5
351	Түүхий эд материал	91,917,090.60	96,676,279.6
35110	Тусгай зориулалттай материал	21,874,977.70	33,150,390.8
35130	Эм боох материал	70,042,112.90	63,525,888.8
354	Хангамжийн материал	20,257,079.40	39,970,074.0
35410	Бичиг хэргийн материал	665,900.00	3,197,344.0
35420	Аж ахуйн материал	10,300,584.40	15,594,454.4
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	325,600.0
35440	Түлш, шатах тослох материал	8,916,065.00	8,916,225.6
35450	Барилгын засварын материал	226,030.00	10,841,950.0
35460	Хүнсний материал	0.00	946,000.0
35470	Бусад хангамжийн материал	148,500.0	148,500.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	239,122,068.90	216,704,596.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	239,122,068.90	216,704,596.7
392	Биет хөрөнгө	234,883,892.30	212,642,420.1
39201	Барилга, байгууламж, орон сууц	165,575,524.00	165,575,524.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,508,667.80	-54,111,785.7
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,880,000.00	28,880,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,645,038.20	-19,209,482.6
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,166,963.00	208,026,963.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-104,584,888.80	-139,570,117.6
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,685,965.00	48,355,965.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,685,965.00	-25,304,646.0
393	Биет бус хөрөнгө	4,238,176.60	4,062,176.6
39301	Програм хангамж	1,860,000.00	1,860,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,361,823.40	-1,537,823.5
39303	Бусад биет бус хөрөнгө	3,740,000.00	3,740,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	351,296,238.80	353,350,950.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
413	Өглөг	0.0	0.0
4136	Бусад өглөг	0.0	0.0
41361	Байгууллагад төлөх өглөг	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	410,098,564.3	353,413,223.3
51	Засгийн газрын хувь оролцоо	410,098,564.3	353,413,223.3
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	255,441,591.5	255,441,591.5

51101	Өмч: - төрийн	255,441,591.5	255,441,591.5
512	Хуримтлагдсан үр дүн	107,440,536.5	50,755,195.5
51210	Өмнөх үеийн үр дүн	1,083,235,591.5	107,440,536.5
51220	Тайлант үеийн үр дүн	-975,795,055.0	-56,685,341.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,216,436.4	47,216,436.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	410,098,564.3	353,413,223.3

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,588,991,268.5	1,110,935,603.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,390,541,268.5	1,110,935,603.5
120	Нийтлэг татварын бус орлого	769,950,689.0	356,095,286.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	769,950,689.0	356,095,286.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	647,328,186.0	217,246,521.5
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	122,622,503.0	138,848,765.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	620,590,579.5	754,840,316.8
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	620,590,579.5	754,840,316.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	198,450,000.0	0.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	198,400,000.0	0.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	198,400,000.0	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,000.0	0.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,000.0	0.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,565,236,323.5	1,167,620,944.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,565,236,323.5	1,167,620,944.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,565,236,323.5	1,167,620,944.5
2104	Хангамж, бараа материалын зардал	76,555,292.8	33,536,142.4
210401	Бичиг хэрэг	11,587,200.0	4,599,180.0
210402	Тээвэр, шатахуун	17,019,421.8	18,115,132.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,948,671.0	10,821,830.0
2105	Нормативт зардал	1,198,207,221.7	169,691,498.2

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,189,784,221.7	159,188,598.2
210502	Хоол, хүнс	8,423,000.0	10,502,900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,903,933.0	9,188,050.0
210604	Урсгал засвар	6,903,933.0	9,188,050.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,283,569,876.1	955,205,253.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,255,314,979.0	904,257,781.6
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,254,897.1	50,947,472.2
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-976,245,055.0	-56,685,341.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-976,245,055.0	-56,685,341.0

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	255,441,591.5	47,216,436.4	1,083,235,591.5	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	255,441,591.5	47,216,436.4	1,083,235,591.5	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(976,245,055.0)	-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	255,441,591.5	47,216,436.4	106,990,536.5	-
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	255,441,591.5	47,216,436.4	106,990,536.5	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	255,441,591.5	47,216,436.4	106,990,536.5	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(56,685,341.0)	-
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	255,441,591.5	47,216,436.4	50,305,195.5	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,466,368,765.5	972,086,838.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,267,918,765.5	972,086,838.3
120	Нийтлэг татварын бус орлого	647,328,186.0	217,246,521.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	647,328,186.0	217,246,521.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	647,328,186.0	217,246,521.5
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	620,590,579.5	754,840,316.8
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	620,590,579.5	754,840,316.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	198,450,000.0	0.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	198,400,000.0	0.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	198,400,000.0	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,000.0	0.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,000.0	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,408,161,036.0	1,002,296,890.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,408,161,036.0	1,002,296,890.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,408,161,036.0	1,002,296,890.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,408,161,036.0	1,002,296,890.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,408,161,036.0	1,002,296,890.6
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	58,207,729.5	-30,210,052.4
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.0	28,530,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	28,530,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	28,530,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.0	28,530,000.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	144,596.0	58,802,325.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,352,325.5	62,273.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баруун Зуунмод ББН өрхийн эрүүл мэндийн төвийн зорилго нь “Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлж, чадваржуулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах”-д оршино. Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2 дахь заалт - “Өрхийн ЭМТ” нь хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр нөхөрлөл хэлбэрээр байгуулагдсан ашгийн бус хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм. 2023 онд нөхөрлөлийн гишүүд, дарга-1, Их эмч-10, сувилагч мэргэжилтэн-14, эмнэлэгийн бусад ажилтан-10 гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв нь өрх бүрд хүрч үйлчлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, чадавхжуулах эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 тушаалаар дотоод хяналтын журам баталж, дотоодын хяналтын баг жилд 2 удаа тооллого хийж хяналтын бүртгэл дээрх тоон дүнтэй харьцуулан шалгасан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд 2023 онд хяналт шалгалт хийгээгүй байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагад мөрдөгдөх "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,054.7 мянган төгрөгөөр буюу 0,5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	112,174.2	136,646.4	24,472.2
Үндсэн хөрөнгө	239,122.1	216,704.6	(22,417.5)
Нийт хөрөнгө	351,296.2	353,351.0	2,054.7
Өр төлбөр	-	0.0	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	410,098.6	353,413.2	(56,685.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	410,098.6	353,413.2	(56,685.3)

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, бараа материал, өмнөх оноос өсөж, үндсэн хөрөнгө, эздийн өмчийндансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 24,472.2 мянган төгрөгөөр өссөн нь 237,159.67 мянган төгрөгийн хангамжийн материал бэлтгэн, 212,687.49 мянган төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс нь 22,417.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 28,530.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн боловч 50,947.47 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой байна.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 56,685.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээ, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн Засаг дарга болон Эрүүл мэндийн газрын дарга нартай гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж ажилласан байна.

Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв нь гүйцэтгэлээр 972,086.8 мянган төгрөг, урд оны шилжих үлдэгдэл 58,802.3 мянган төгрөг нийт үйл ажиллагааны мөнгөн орлого 1,038,889.2 мянган төгрөг, 1,002,296,89 мянган төгрөгийн зардал гарган, 62,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв нь өөрийн эх үүсвэрээр 28,530.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтийг 1,588,991.3 мянган төгрөгийн нийт орлогоор сонгосон.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоон сонгосон суурь үзүүлэлтээс тооцож, төлөвлөлтийн материаллаг байдлыг 23,834.9 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбар болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,876.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн, дотоод албан томилолт, гар утасны ярианы төлбөрт зардал гаргаагүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээлэл байршуулахаас 159 мэдээллийг хугацаанд, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан мөн 5 сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг бөөн дүнгээр мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж холбогдох мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулж байх.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв 2023 оны эхний хагас жилийн баримтад завсрын аудит хийж, аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

төгрөгөөр/

/мянган

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	251,156.0	2	251,156.0	100
Нийт дүн	2	251,156.0	2	251,156.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 53,002.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 28,530.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 24,472.2 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээлэл байршуулахаас 159 мэдээллийг хугацаанд, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан мөн 5 сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг бөөн дүнгээр мэдээлсэн зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "... хөрөнгө, мөнгө зарцуулах, ... шийдвэр", гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж холбогдох мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулж байх.

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2023 оны бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 24,472.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж бараа материал нөөцөлсөн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-ийн 15.1.6 дахь заалт "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээгээр бэлтгэх нөөцлөх" Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж

ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг нэр төрөл, эдийн засгийн ангиалалаар нь тайлагнаагүй зөвхөн бараа үйлчилгээний бусад зардал (210901) гэсэн ангилалаар тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 190 дүгээр тушаал баталсан “Зардлын эдийн засгийн ангиалал ашиглах заавар” болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 190 дүгээр тушаал баталсан “Зардлын эдийн засгийн ангиалал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023 оны бараа материалын үлдэгдлийг өмнөх оноос 24,472.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж бараа материал нөөцөлсөн.	1	24,472.2					1	24,472.2
Шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээлэл байршуулахаас 159 мэдээллийг хугацаанд, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан мөн 5 сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг бөөн дүнгээр мэдээлсэн.	1	-					1	-
Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг нэр төрөл, эдийн засгийн ангиалалаар нь тайлагнаагүй зөвхөн бараа үйлчилгээний бусад зардал (210901) гэсэн ангилалаар тайлагнасан байна.	1	-					1	-
Дүн	3	24,472.2					3	24,472.2